



ОРХОН СУМЫН МОНГОЛ  
АРДЫН НАМЫН ХОРООНД

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.04.30 № СНА-2022/04-НА-09  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Орхон сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Орхон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Орхон сумын Монгол Ардын намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

## Дүгнэлт

Орхон сумын Монгол Ардын намын хорооны Орхон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Орхон сумын Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /...7... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Орхон сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

СЭЛЭНГЭ АЙМАГ ОРХОН СУМЫН ИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Мөрийн хөтөлбөрийн зорилго: Орон нутгийн сонгуульд МАН-аас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх, иргэн бүрийн санал санаачилга, идэвх оролцоонд тулгуурлан эв эеийг хичээн Орхон нутгаа хөгжүүлж сэтгэл хангалуун амьдралыг бий болгох.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙГМИЙН БОДЛОГО

*Нэг. Эрүүл мэндийн бодлогын хүрээнд:*


- 1.1.1 Эмч эмнэлгийн мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллахад бодлогоор дэмжинэ.
- 1.1.2 Эмч эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтад хамруулж чадавхжуулна.
- 1.1.3 Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, амьдралын зөв хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор "Зөв хооллолт - Идэвхтэй хөдөлгөөн - Эрүүл мэнд" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.1.4 Яаралтай тусламжийн багаж тоног төхөөрөмжөөр хангаж эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг сайжруулна.
- 1.1.5 Эх нярайн эрүүл мэндийн хяналтыг сайжруулж эх нярайн эндэлгүй ажиллана.
- 1.1.6 Иргэн бүрийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагддаг болгож хэвшүүлнэ.

*Хоёр. Боловсролын бодлогын хүрээнд:*

- 1.2.1 ЕБС, цэцэрлэгийн хамран сургалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.2.2 ЕБС, СӨБ-ын багш нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, туршлага судлуулах, сургалтад хамруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.2.3 Өсвөр үеийнхэнд эх оронч үзэл, уламжлалт зан үйл сэтгэлгээг төлөвшүүлэх, аймаг, сумынхаа түүх, соёлыг мэддэг, дуртай нутаг орноороо бахархах үзэл хүмүүжилтэй, амьдралын зөв дадал хэвшилтэй, боловсролтой иргэн болгон төлөвшүүлэх "Бид Орхон сумын ирээдүйн эзэд" дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. Өсвөр үеийнхэнд эх оронч үзэл, уламжлалт зан үйл сэтгэлгээг төлөвшүүлэх зорилгоор аймаг, орон нутгийн түүх соёл, уламжлалт зан үйл, үнэт зүйлсийн тухай мэдлэгийг сургалтын агуулгад багтаан олгоно.



- 1.2.4 Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх урлаг, спорт, оюун ухааны спортыг дэмжиж секц дугуйланг хичээллүүлнэ.
- 1.2.5 Жил бүр зуны улиралд малчид, тариаланч, ногоочдын хүүхдүүдийг багийн цэцэрлэгт хамруулж сургуулийн өмнөх боловсрол олгох ажлыг тасралтгүй зохион байгуулна.



*Гурав. Соёл урлагийн бодлогын хүрээнд:*

- 1.3.1 Соёл урлагийн мэргэжилтэй салбарын ажилтны тоог нэмэгдүүлэх, мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, нийгмийн баталгааг сайжруулна.
- 1.3.2 Соёл урлагийн үзвэр үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, соёлын өвийг хадгалж хамгаалах, түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг сэргээн засварлах, орон нутаг сурталчлах танхимын үзмэрийн тоог нэмэгдүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр орон нутгийн онцлог тулгуурласан дунд хугацааны стратеги төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангана.
- 1.3.3 Номын сангийн баяжилтыг нэмэгдүүлж алслагдсан багийн иргэдэд нүүдлийн номын сангийн үйлчилгээг хүргэх, уншигчдын тоог нэмэгдүүлнэ.
- 1.3.4 Алслагдсан хөдөөгийн иргэд болон малчид тариаланчдад соёл урлагийн иж бүрэн үйлчилгээг цогцоор нь хүргэнэ.
- 1.3.5 Хүүхэд багачуудын үндэсний хэл соёл, уламжлал, зан заншлаас суралцах, өвлүүлэн хөгжүүлэх чиглэлээр соёлын олон талт ажлыг зохион байгуулна.
- 1.3.6 Орон нутаг сурталчлах танхимын үйл ажиллагааг тогтмолжуулж музейн стандартад нийцүүлэн тохижуулна.

*Дөрөв. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.*

- 1.4.1 Волейболын спортын залгамж халааг бэлтгэж, сургалтын шаардлагатай хэрэглэгдэхүүнээр хангахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.4.2 Бөхийн спортыг хөгжүүлж түүнд шаардагдах дэвжээ бусад хэрэгслээр хангана.
- 1.4.3 Биеийн тамирын арга зүйчтэй болж нийтийн биеийн тамираар дамжуулан "Хөдөлгөөн эрүүл мэнд" уриан дор иргэдийн хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор фитнес төв байгуулна.
- 1.4.4 Сумын аварга шалгаруулах тэмцээний төрлийг нэмэгдүүлэх, волейболын спортыг сонирхогчдод зориулан ахмад болон залуучууд насны ангиллаар зохион байгуулна.

1.4.5 Үндэсний спортоор хичээллэх орчныг бүрдүүлэн бүсийн чанартай тэмцээнийг зохион байгуулна.

*Тав. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого шинэчлэлийн хүрээнд:*

- 1.5.1 Сум хөгжүүлэх сан, бага орлоготой иргэдийг ажлын байранд зуучлах арга хэмжээ, 40-өөс дээш насны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 1.5.2 Хөдөлмөрийн насны ажил хөдөлмөр эрхэлдэггүй иргэдийн өрхийн чадамжийн судалгаа гаргаж тухайн өрхийн онцлогт тохирсон аж ахуй эрхлэх боломжийг бүрдүүлнэ.
- 1.5.3 Төрийн албанаас өндөр настны тэтгэвэрт гарсан ахмад настны ажлын туршлагыг хүүхэд залуучуудад өвлүүлэх зорилго бүхий "Ахмадын зөвлөх баг" арга хэмжээг зохион байгуулна.
- 1.5.4 Сумын хэмжээнд 70-аас дээш насны ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд эмнэлэгт үзүүлэх, шинжилгээ хийлгэх, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхэд дугаар харгалзахгүйгээр үйлчилнэ.
- 1.5.5 Ахмад настанд үзүүлэх төрийн үйлчилгээ, тусламж, хөнгөлөлтийг сайжруулах ажлыг зохион байгуулна.
- 1.5.6 Улс, аймаг сумын сайн малчидтай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулж жилд амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой мал маллах сонирхолтой залуу гэр бүлийг дэмжиж ажиллана.
- 1.5.7 Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын чиглэлээр ГХУСА33, хамтарсан багийн ажлыг сайжруулна.
- 1.5.8 Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй иргэдэд нийгмийн даатгалын хуулийн талаар сургалт, сурталчилгаа хийж, сайн дурын болон ЭМД-д бүрэн хамруулж ажиллана.
- 1.5.9 Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг үйлдвэр, иргэн ААН-үүдэд орон нутгийн иргэдээс сүү, мах, ногоо, өрхийн үйлдвэрлэл зэрэг бүтээгдэхүүний худалдан авалт хийдэг жишиг тогтооно.
- 1.5.10 Суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагыг дээшлүүлж ажиллагсдыг нийгмийн даатгалд хамруулах бодлого баримталж ажиллана.

## ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

*Нэг. Хөдөө аж ахуйн бодлого, шинэчлэлийн хүрээнд:*

- 2.1.1 Тариалангийн талбай ашиглалтад тавих хяналтыг сайжруулж талбайн тооллогыг үе шаттайгаар зохион байгуулна.
- 2.1.2 Хөрсний эвдрэл үүссэн газруудад ногоон байгууламжийг шинээр нэмэгдүүлнэ.
- 2.1.3 Хүлэмжийн аж ахуйг дэмжиж хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, жимс жимсгэнэ тариалах иргэдийн санал санаачилгыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.1.4 Суурин болон зуслангийн бэлчээрт ойр тариалан, төмс хүнсний ногооны талбайг хашаажуулах иргэдийн санал санаачилгыг дэмжиж ажиллана.
- 2.1.5 Зоорь барих, хүнсний ногоо даршлах үйлдвэр цех байгуулах хүсэлтэй иргэн, аж ахуй нэгжийн санал санаачилгыг дэмжиж төмс, хүнсний ногоо хадгалалтын стандартыг сайжруулна.
- 2.1.6 Сүү, цагаан идээ, хүнсний болон даршилсан ногоо, загас загасан бүтээгдэхүүн зэрэг өрхийн үйлдвэрлэлд тулгуурласан сумын брэнд хөтөлбөр боловсруулж нэр төрлийг ИТХ-аар батлуулан борлуулалтыг бодлогоор дэмжинэ.
- 2.1.7 Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх “Сэлэнгэ - Илгээлтийн эзэн III” аянд орон нутгийнхаа онцлогт тохируулан түүчээлж оролцоно.
- 2.1.8 Орхон хонь маллах дур сонирхолтой малчдыг дэмжих замаар Орхон хонины тоо толгойг нэмэгдүүлнэ.
- 2.1.9 Жил бүр сумын хэмжээнд өвсний фонд бүрдүүлнэ.
- 2.1.10 Малчид мал бүхий иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үхэр сүрэгт гүн хөлдөөсөн үрийн хээлтүүлэг явуулах, цэвэр хээлтүүлэгч эцэг мал худалдан авч эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр гаргасан санал, санаачилгыг дэмжинэ.
- 2.1.11 Мал эмнэлгийн үйлчилгээг өрх бүрд хүргэх мал, амьтныг гоц халдварт, халдварт зооноз, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт, ариутгал халдваргүйтгэлийг графикт хугацаанд чанартай хийж гүйцэтгүүлж хяналтыг сайжруулна.

*Хоёр. Байгаль орчны бодлого, шинэчлэлийн хүрээнд:*


- 2.2.1 Сумын төв суурин газарт айл өрх бүрийн хашааны 10 хувийг моджуулах ажлыг зохион байгуулна.

- 2.2.2 Малчдын бүлэгт ойн сан бүхий газар, ан амьтан байгаль орчныг хамгаалах гэрээ байгуулан үнэлэлт дүгнэлт хийж хамгаалалтыг сайжруулна.
- 2.2.3 Сумын хүн амын ундны усны эх үүсвэр гүний худгийн усыг эрүүл ахуйн шинжилгээнд хамруулж энгийн хамгаалалтын бүс тогтоох, <sup>4317143998</sup>булагшандын эхийг хамгаалах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.
- 2.2.4 Газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлэн, өмчлөгдсөн газруудыг кадастрт оруулж кадастрын мэдээллийн санд бүрэн хамруулна.
- 2.2.5 Газар эзэмшил ашиглалтыг сайжруулж, газрыг зориулалтын дагуу ашиглаагүй иргэн, аж ахуйн нэгжийн газрыг дахин төлөвлөлтөд оруулна.
- 2.2.6 Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааны үйл ажиллагааг олон нийтэд ил болгоно.
- 2.2.7 Баг хорооны нутаг дэвсгэр дэх нийтийн эдэлбэр газрын эрүүл ахуй ариун цэврийн шаардлагыг хангуулах ажлыг зохион байгуулна.

#### ГУРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ДЭД БҮТЦИЙН БОДЛОГО

- 3.1 Эмнэлгийн граш, моргийн барилгыг засварлаж стандартад нийцүүлнэ.
- 3.2 Түргэн тусламжийн авто машины парк шинэчлэлт хийнэ.
- 3.3 Соёлын төвийн хөгжмийн техник аппаратурын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- 3.4 Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилгоор стандартад нийцсэн спорт заалтай болох ажлыг холбогдох дээд шатны байгууллагад уламжилна.
- 3.5 ЕБС, Соёлын төв, ЗДТГ- зэрэг төр төсвийн байгууллагуудын барилгыг цэвэр бохир усны системд холбоно.
- 3.6 42-р зөрлөгийн хайрган хучилттай авто замаас гудамж талбайн намагшсан хэсгийн 1км замыг засварлана.
- 3.7 Шийр, 42-р зөрлөгт гудамжны гэрэлтүүлгийг 3-4 хэсэгт төвлөрсөн байдлаар шийдвэрлэж, гүний худгийг ухаалаг тоолууртай болгоно.
- 3.8 Интернэтийн байгууламжийг ашиглалтад оруулна.
- 3.9 Гудамжны гэрэлтүүлгийн урсгал засварыг тогтмол хийж, Дэнж, Цагаан овоо, Наран хэсэгт өргөтгөл хийнэ.
- 3.10 Сумын төвийн Наран хэсгийн айл өрхийн дунд дулааны ерөнхий шугамын ажлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.
- 3.11 Угтах үдэх хаалганы орчимд сумын брэнд бүтээгдэхүүний худалдаа үйлчилгээ эрхлэх орчин нөхцөлийг бүрдүүлж, цахилгаан эрчим хүчээр хангана.

- 3.12 Хүүхэд залуучуудын талбайд хөл бөмбөг, волейболын задгай талбайг шинээр байгуулж арчлалт хамгаалалтыг сайжруулна.
- 3.13 Сумын төвийн тодорхой цэгүүдэд камержуулалт хийж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.
- 3.14 Төрийн албан хаагчдыг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг судлаж хэрэгжүүлнэ.




#### ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 4.1 Шийдвэр гаргах түвшинд иргэд олон нийтийн оролцоог хангадаг тогтолцоог бүрдүүлнэ.
- 4.2 [www.selengeorkhon.mn](http://www.selengeorkhon.mn) веб хуудастай болж сумын танилцуулга, цаг үеийн мэдээ мэдээлэл, төсөв санхүү, хүний нөөц, худалдан авах ажиллагаа болон бусад төр төсвийн байгууллагын мэдээ, мэдээллийг байршуулж мэдээллийн ил тод байдлыг хангана.
- 4.3 Интернет харилцаа холбооны давуу байдлыг ашиглан иргэдэд мэдээллийг жигд хүртээмжтэй хүргэх зорилгоор урсдаг зарын самбар, Facebook хаяг, суурин утсаар мэдээлэл хүргэж, санал сонсож, хариуг хүргэх ажлыг түргэн шуурхай шийдвэрлэж ажиллана. Орхоны мэдээ сонины мэдээллийн цар хүрээг өргөжүүлж орон нутагт болж буй үйл явдлыг нээлттэйгээр мэдээллэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.
- 4.4 Төр, төсвийн байгууллагуудын үйл ажиллагаанд тавих хяналтын үр нөлөөг дээшлүүлж, төрийн үйлчилгээний түргэн шуурхай ил тод байдлыг хангуулж ажиллуулна.
- 4.5 Сурлага, урлаг, спортоор амжилт гаргасан оюутан сурагчдад холбогдох журмын дагуу дэмжлэг үзүүлж ажиллана.
- 4.6 Суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд ахмадууд, хүүхэд залуучууд, сумын хөгжлийг дэмжсэн тэдний эрх ашгийг хамгаалахад чиглэсэн олон талт ажил арга хэмжээг нийгмийн хариуцлагын гэрээ байгуулах замаар хэрэгжүүлнэ.
- 4.7 Багийн иргэдийн нийтийн хурлыг тогтмол зохион байгуулж цаг үеийн мэдээллийг хүргэж ажиллана.
- 4.8 Төрийн албан хаагчийг чадавхжуулах, хариуцлагыг дээшлүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.



- 4.9 Гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахин хамгаалах үйл ажиллагаанд олон нийт иргэдийн сайн дурын оролцоог нэмэгдүүлнэ.
- 4.10 Хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг сурагч, эцэг, эх иргэд, олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулна.
- 4.11 Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй байгууллага, хамт олон хөдөлгөөн өрнүүлнэ.
- 4.12 Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг цагдаагийн байгууллага, багийн Засаг дарга, ХАА-н тасагтай хамтран зохион байгуулж, бод малыг бүртгэлжүүлэх ажлыг хийнэ.
- 4.13 Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийг түр хамгаалах байр, мэдээлэл зөвлөгөөг авах төвийг ажиллуулна.



ОРХОН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

